



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Соёл, урлагийн газрын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/05/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: Natsagdorjs@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261628 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn

Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261628 Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.МӨНХЗУЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 07/1186
танай _____-ны № _____-т

Татгалзсан санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Соёл, урлагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийхээр байсан.

Соёл, урлагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна. Бидний үзэж байгаагаар Татгалзсан санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас нэгтгэсэн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Татгалзсан дүгнэлтийн үндэслэл

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайланг нэгтгэж Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанаас 19 хоног хоцроож Төрийн аудитын байгууллагад ирүүлснээс аудит хийж дүгнэлт гаргах цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл үүссэн. Мөн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, тайлбарын иж бүрдлийг хангаж ирүүлээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байсан.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САМБУУНЯМ